

**“УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСӨЛД”
ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО**

№	БАЙГУУЛЛАГА, ИРГЭН	Засгийн газрын тогтоолын төсөлд өгсөн санал	Тайлбар, төсөлд тусгасан байдал
1.	Иргэн С.Гэрэлт-од syndshde@gmail.com	Сайн байна уу? Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байна. Би цэргийн нисэхэд амьдралаа зориулж гавьяаныхаа амралтад гарсан хүн байгаа юмаа. Хуулийн төсөлд Улсын нисэхийн багц дүрмийг нэр томьёоны тодорхойлолтод тусгавал зүгээр санагдлаа.	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д “Улсын нисэхийн багц дүрэм” гэж тусгасан.
2.	Иргэн С.Баярхүү Bayrhuu690@gmail.com	Улсын Нисэхийн тухай хуулийг шинэчлэн найруулж байгаад иргэн миний бие таатай байгаагаа илэрхийлье. Тухайн хуулийн заалтад өөрийн саналаа илэрхийлж байна. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг “Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих” гэж өөрчлөн найруулах саналтай байна.	Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг “Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих” гэж өөрчлөн найруулсан.
3.	Алба хаагч С.Ганбат saneregganbat@gmail.com	Сайн байна уу? Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байна. Би цэргийн нисэхэд ажиллаж байгаа. Хуулийн төсөлд Улсын нисэхийн багц дүрмийг нэр томьёоны тодорхойлолтод тусгавал зүгээр санагдлаа.	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д “Улсын нисэхийн багц дүрэм” гэж тусгасан.
4.	Алба хаагч Э.Будрагчаа budragchaa@internet.ru	Сайн байна уу? Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байна. Миний бие Зэвсэгт Хүчний 303 дугаар ангийн нисэх хэсгийн борттехникчээр ажилладаг. “ахмад Э.Будрагчаа” Гэрчилгээжүүлэлт системд дижитал хандалт, QR, цахим баталгаажуулалт нэвтрүүлэх.	Хуулийн төсөлд тухайн чиглэлээр зохицуулалтыг нэмэгдүүлэхгүй, “Улсын нисэхийн багц дүрэм”-ийн 2 дугаар хавсралт болох “Нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах дүрэм”-д тусгах нь зүйтэй гэж үзсэн.
5.	Иргэн У.Нарангарав Munkhorgil130219@gmail.com	Амрыг эрье! Би агаарын цэргийн ангийн алба хаагч энэ газраас ажил амьдралаа эхлүүлж 10аад жил болсон байна. Тийм ч учраас энэ салбартаа бүх сэтгэлээ зориулж ажилдаг бөгөөд нисэхийн салбар маань улам их хөгжиж сайн сайхан болоосой бусад улсын нисэхийн салбараас битгий дутаасай гэж боддог. Тиймээс та бүхний хийж байгаа улсын нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгааг дэмжиж байгаа бөгөөд тэдгээр өөрчлөлтүүд бидэнд тулгамдсан асуудлуудыг шийдэхэд сайнаар нөлөөлж цаашид хэрэгтэй гэж бодож байна. Та бүхний ажилд амжилт хүсье. Хөх тэнгэр нь цэлмэг байг.	Хуулийн төслийг дэмжсэн.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ